



Авлигатай тэмцэх ажлыг эрчимжүүлэх, ил тод байдлыг сайжруулах ажлын тайлан

2020.12.20

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Биелэлт
Нэг. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх		
1.	Авлигатай тэмцэх төлөвлөгөө гарган, батлуулах	<p>Төвийн хэмжээнд хэрэгжүүлэх “Авлигатай тэмцэх ажлыг эрчимжүүлэх, ил тод байдлыг сайжруулах” төлөвлөгөөг боловсруулан 2020 оны 1 сарын 23-нд Захирлаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаа. Энэхүү төлөвлөгөөг төвийн цахим хуудаст байршуулсан.</p> <p>http://donor.mohs.mn/web/wp-content/uploads/2017/10/Avligiin_esreg_tuluvluguu_2020.pdf</p>  <p>ЦССУТ-ийн авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө</p> <p>ЦССУТ-ийн авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө</p> <p>ЦССУТ-ийн 2016 оны авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө</p> <p>"Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс алгд бай, ил тод байдлыг сайжруул" сарын аяны төлөвлөгөө</p> <p>ЦССУТ-ийн 2017 оны авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө</p>
2.	Төвийн ажилтнуудад ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалтыг авлигатай тэмцэх газартай хамтарч зохион байгуулах	<p>Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтууд:</p> <ul style="list-style-type: none"> - 2020 оны 06 сарын 26-ны өдөр АТГ-аас хамтран зохион байгуулсан “Авилга, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтанд төвийн 6 ажилтан, ЭБАТ хамрагдсан. - Эмнэлгийн мэргэжилтний сахилга, хариуцлага, ёс зүйн сургалтуудад Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албан нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвийг тусган 6 удаа нийт ажилчдад зохион байгууллаа. Энэхүү сургалтанд давхардсан тоогоор төвийн нийт 76 ажилтан, Цусны салбар төвийн эрхлэгч, эмч нар тус тус хамрагдсан. - Төвийн ХАСХОМ гаргах албан тушаалтнууд, ЭБАТ Авлигатай тэмцэх газрын ЭБАТ-ын нэгдсэн сургалтад 11 сарын 22-ны өдөр цахим сургалтанд оролцсон бөгөөд тус төвийн фейсбүүк хуудсанд

сургалтыг байршуулж, цахимаар ХАСХОМ мэдүүлэх гарын авлагыг ажилтнуудад олгосон.



Ёс зүй, харилцаа, хандлагын чиглэлээр зохион байгуулсан сургалтууд:


3. Төвийн удирдах ажилтны хөрөнгө орлогын мэдүүлэгт хяналт тавьж, цаг тухайд нь ЭМЯ-нд хүргүүлэх

- Төвийн удирдах 3 албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд гаргуулан баталгаажуулж ажиллаа.


- Мөн шинээр нэр дэвшсэн 2 албан тушаалтны ХАСУМ-ыг АТГ-т хүргүүлэн ирүүлсэн хариуны дагуу томилгоог хийсэн. Энэхүү ажилтны Хөрөнгө орлогын мэдүүлгийг томилогдсоноос хойш 30 хоногийн дотор гаргуулан баталгаажуулж ажилласан.


АТГ-т ЦССҮТ-ийн хамаарал бүхий этгээдийн нэрсийн жагсаалт хүргүүлж, тэднээс 2019 оны ХАСХОМ гаргуулсан. Дунд шатны менежерүүдийг АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулсан. Худалдан авах ажиллагаатай холбоотой мэдэгдэл, тайлбарыг хуулийн хугацаанд гаргуулан АТГ-ын программд оруулан ажиллаж байна.



- 2020 онд нийт 5 ажилтан ХАСХҮМ гаргаж, 6 ажилтныг АТГ-ын сургалтад бүртгүүлж, бүрэн чанартай хэрэгжсэн байна.

4.	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг цахим хуудас, мэдээллийн самбаруудаар байршуулж, сурталчлах</p>	<p>ЦССУТ нь Авлигын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэх, ил тод байдлыг сайжруулах зорилгоор төвийн цахим хуудсанд Авлигын эсрэг http://donor.mohs.mn/web/?p=2592 цэс үүсгэн мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна. Энэхүү цэсэнд тус төвөөс Авлига, хүнд сурталын эсрэг зохион байгуулан хэрэгжүүлж буй үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээ, сургалтын материал зэргийг байршуулан ажиллаж байна.</p>	
----	--	---	---

Хоёр. Ил тод байдлыг сайжруулах

5.	<p>Ерөнхий захирлын гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад ерөнхий захирлын тушаал, шийдвэрийг цахим хуудсанд байршуулах</p>	<p>Төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад Ерөнхий захирлын тушаал, шийдвэрийг байгууллагын цахим хуудсанд байршуулан ил тод ажиллаж байна. Ерөнхий захирлын 2020 оны нийт 12 тушаалыг байгууллагын цахим хуудсанд байршуулжээ. http://donor.mohs.mn/web/?p=580</p>	
----	--	---	--

6.	Ажиллагсад, үйлчлүүлэгчдээс ирсэн өргөдөл, санал хүсэлтийг хүлээн авах нөхцлийг бүрдүүлэх, улирал тутам Удирдлагын зөвлөлөөр хэлэлцэж, шийдвэрийг цахим хуудсанд байршуулах	2020 оны туршид тус төвийн Удирдлагад нийт 56 өргөдөл, хүсэлт бичгээр ирсэн бөгөөд тухай бүр хариуцах албан тушаалтанд хуваарилан шийдвэрлүүлж 100 хувь шийдвэрлэн ажилласан байна. Улирал бүр өргөдөл, санал хүсэлтийн шийдвэрлэлтийг Удирдлагын зөвлөлд танилцуулан байгууллагын цахим хуудсанд байршуулж байна. http://donor.mohs.mn/web/?p=1362	 <p>Санал, гомдол, хүсэлтийг шийдвэрлэн байдал</p> <p>Санал гомдлын хороо байгуулахтай өгсг</p> <ul style="list-style-type: none"> 2017 оны 3-р улирал 2017 оны 2-р улирал 2017 оны 1-р улирал <p>2016 он</p>
7.	Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох	Засгийн газрын 2019 оны 5, 382 дугаар тогтоолыг үндэслэн төвийн ажиллагсдад Мөнгөн урамшуулал олгох журмыг шинэчлэн батлуулсан. Ингэснээр ажилтнуудын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ боловсронгуй болж, үнэлгээ илүү бодитой болсон. Энэхүү журманд ажлын цаг ашиглалт, чанарын шалгуур үзүүлэлт, ёс зүй харилцаа хандлага, халдвар хамгааллы дэглэмийн мөрдөлтийн үнэлгээг холбогдох алба, баг, хорооноос гаргуулан авч байхаар тогтоосон. Цалин урамшуулал олгох журам, тооцох журмыг нийт ажилчдад танилцуулах сургалтыг 2020 оны 1, 7 сард зохион байгуулсан бөгөөд нийт 58 ажилтан хамрагдсан.	
8.	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулах, ил тод нээлттэй ажиллах	“Шилэн данс” цахим хаягт мэдээлэл байршуулах ажлын төлөвлөгөөг төвийн ерөнхий захирлын 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн А/21 тоот тушаалаар шинэчлэн боловсруулж батлуулан мөрдөн ажилласан. Энэ хугацаанд Эрүүл мэндийн яамны хяналт шинжилгээ үнэлгээний газарт тайланг 3 удаа цаасаар болон цахимаар илгээж, Үндэсний аудитын газрын нийцлийн аудитаар амжилттай шалгуулан ажилласан байна. Мэдээллүүдийг хуулийн хугацаанд “Шилэн данс” цахим хаяг, байгууллагын вэб хаяг, өөрийн байгууллагын мэдээллийн самбарт байршуулан ажилласан. Шилэн дансны ил тод байдал, мэдээллийг хугацаанд нь байршуулсан эсэхт төвийн Дотоод аудит, хяналт үнэлгээний багаас нийт 2 удаа аудит хийж үнэлгээ, дүгнэлтийг гарган ажиллаа.	
9.	Сул ажлын байрны зарыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар ил тод	Төвийн шаардлагатай орон тоог нэмж авч ажлуулах Ажилтан сонгон шалгаруулах, дадлагажуулан, туршилтаар ажлуулах, үндсэн ажилтнаар томилох журмын дагуу ажиллаж байна.	

<p>нээлттэйгээр зарлан сонгон шалгаруулалт хийх</p>	<p>Сул ажлын байрны талаар тус төвийн www.donor.mohs.mn цахим хуудас, зууны мэдээ сонин, facebook хуудсуудад тухай бүр шинэчлэн байршуулдаг. Мөн Эрүүл мэндийн хөгжлийн төвийн www.chd.mohs.mn цахим хуудаснаа тогтмол байршуулж байна.</p> <p>Шинээр ажилд орж буй хүмүүсийг Удирдлагын зөвлөлийн хурлаар оруулж шийдвэрлүүлэн, ажиллаж байна. Шинээр ажилд орж буй ажилтнуудад байгууллагын үйл ажиллагаа болон тасаг нэгжийн ажилтай танилцуулах, баримжаа олгох сургалтыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна.</p> 
<p>10. Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, нийт ажиллагсдад таниулах сургалт зохион байгуулах, ажиллагсдын давхар ажил эрхлэлтийн талаар судалгаа гаргах</p>	<p>ЦССҮТ-ийн ажилтнуудын давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гарган төвийн цахим хуудасны Авлигын эсрэг цэсэнд байршуулсан. Одоогоор давхар ажил эрхлэгч тус төвд байхгүй байна.</p> 

Тайлан гаргасан: ЦССҮТ-ийн ЭБАТ

Я.Тогтохням